



ХҮМҮҮНЛЭГИЙН  
УХААНЫ  
ИХ СУРГУУЛЬ

## ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот  
Утас: (976-11) 318 524

### Түр журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12.1 дахь заалт, "Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн дүрэм"-ийн 5.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Төгсөгч оюутнууд кредит нөхөн судлахад баримтлах түр журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг төгсөгч оюутнуудад шуурхай мэдэгдэж хэрэгжилтийг хангах арга хэмжээ авахыг Сургалт, судалгааны хөгжил, аудит үйлчилгээний алба /Б.Хишигтогтох/, Мэдээлэл технологийн алба /С.Диваасамбуу/, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд /А.Амаржаргал, Г.Амарбаясгалан, Т.Алтанцэцэг, Д.Уламбаяр/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.ЧУЛУУНДОРЖ

01276



Захирлын 2016 оны 09 - р сарын 16 -ны өдрийн  
СУРГУУЛЬ БСБ 438 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

### Төгсөгч оюутнууд кредит нөхөн судлахад баримтлах түр журам

1. Энэхүү журмын зорилго нь ХИС 2016-2017 оны хичээлийн жилээс сонгох сургалтын тогтолцоонд бүрэн шилжсэнтэй холбогдуулан кредит цаг дутуу судалсан төгсөх оюутнуудын кредит нөхөн судлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
2. Кредит цаг дутуу судалсан төгсөх оюутан гэдэгт тухайн хичээлд огт хамрагдаагүй, F үнэлгээ авсан, хичээлийн явцад суралцахаас татгалзаж хаясан оюутныг ойлгоно.
3. Энэхүү журам нь 2016-2017 оны хичээлийн жилийн намрын улиралд идэвхтэй суралцаж буй өдрийн бакалаврын 4-р түвшин, оройн бакалаврын 2-р түвшний оюутнууд болон өмнөх жилүүдэд кредит дутуу судалж төгсөлт нь хойшилсон оюутнуудад хамаарна.
4. Энэхүү журмын 3 дахь хэсэгт заасан оюутнуудад зориулан кредит нөхөх түргэвчилсэн сургалтыг дараах хуваариар зохион байгуулна.
  - 4.1 Намрын улиралд идэвхтэй суралцаж буй өдрийн бакалаврын 4-р түвшин, оройн бакалаврын 2-р түвшний кредит дутуу судалсан оюутнуудад 2016.12.26-2017.01.22 хооронд
  - 4.2 Өмнөх жилүүдэд кредит дутуу судалсан төгсөлт хойшилсон оюутнуудад 2016.11.01-2016.12.01 хооронд
5. Өмнөх жилүүдэд төгсөлт хойшилсон оюутнууд 4.2-т заасан хугацаанд сургалтад хамрагдаагүй буюу дутуу хамрагдсан бол 4.1-д заасан сургалтад хамрагдаж болно.
6. Энэхүү журмын 4.1-д заасан сургалтад 9 багц цагаас илүүгүй, 4.2-т заасан сургалтад 15 багц цагаас илүүгүй хичээлийг оюутнууд сонгон судална.
7. Оюутан ХИС-ийн бакалаврын сургалтын журмын 3.9-д заасан ачаалал болон энэхүү журмын 6-д заасан ачааллыг харгалзан кредит нөхөн судлах эрхтэй.
8. Оюутнууд 4.1-д заасан сургалтад тухайн хичээлийн жилд мөрдөж буй кредитийн үнэлгээний 50 хувийг, 4.2-т заасан сургалтад кредитийн үнэлгээг 100 хувь төлж хамрагдана.
9. Энэхүү журмын 4-т заасан сургалтыг Мэдээлэлийн технологийн алба, Сургалтын алба, бүрэлдэхүүн сургуулиуд хамтран зохион байгуулсугай.
10. Энэхүү журам зөвхөн 2016-2017 оны хичээлийн жилийн намар, өвлийн улиралд үйлчилнэ.